



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

208.	Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Дугаар 35	553
209.	Улсын сайн малчин, Улсын тэргүүний фермер, Улсын тэргүүний малчдын бүлэг, Улсын тэргүүний тариаланч хамт олон, Улсын тэргүүний тариаланч шалгаруулах тухай	Дугаар 39	556
210.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 41	560

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 2 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар
хот

**Жендэрийн үндэсний хорооны
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

С.БАЯРЦОГТ



Засгийн газрын 2015 оны 35 дугаар
тогтоолын хавсралт

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Монгол Улсын Ерөнхий сайд
Орлогч дарга	-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
Гишүүд:	-Эрүүл мэнд, спортын сайд; -Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр); -Нийслэлийн Засаг даргын орлогч; -Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын дэд сайд; -Гадаад хэргийн дэд сайд; -Хууль зүйн дэд сайд; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд; -Уул уурхайн дэд сайд; -Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд; -Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хүний эрхийн үндэсний комиссын жендэрийн асуудал хариуцсан гишүүн (зөвшилцсөнөөр); -Үндэсний статистикийн хорооны дэд дарга (зөвшилцсөнөөр); -Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч (тохиролцсоноор);



-Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Монголын эрэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны Хөгжлийн бодлогын газрын дарга (тохиролцсоноор);

-“Зохистой хөгжлийн жендэр төв”-ийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);

-“Гал голомт” үндэсний хөдөлгөөний тэргүүн (тохиролцсоноор);

-Нийгмийн ардчилал-Монголын эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-Ардчилал эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-“Иргэний зориг” эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-“Шударга ёс” Монголын эмэгтэйчүүдийн нэгдсэн холбооны тэргүүн (тохиролцсоноор);

-Жендэрийн консорциумын тэргүүн (тохиролцсоноор);

-Нөхөн үржихүйн эрүүл мэндийн сүлжээний зохицуулагч (тохиролцсоноор);

-“МОНФЕМНЕТ” үндэсний сүлжээний зохицуулагч (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга

(орон тооны)

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2015 оны 2 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

**Улсын сайн малчин, Улсын тэргүүний
фермер, Улсын тэргүүний малчдын бүлэг,
Улсын тэргүүний тариаланч хамт олон, Улсын
тэргүүний тариаланч шалгаруулах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Болзлын шаардлага хангасан:

а) Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Донгой багийн малчин Ишдоржийн Жамъянсүрэн, Өлзийт сумын Бодонт багийн малчин Баасанцэдэнгийн Дэמידнямбуу, Хайрхан сумын Хайрхан багийн малчин Дарьсүрэнгийн Лхагваа, Хашаат сумын Цайдам багийн малчин Содномын Батмөнх, Цэцэрлэг сумын Хонгорж багийн малчин Дарьмаагийн Отгонбаяр, Эрдэнэбулган сумын 3 дугаар багийн малчин Батбаатарын Ванданшарав, мөн сумын 6 дугаар багийн малчин Гочоогийн Ганбаатар, Эрдэнэмандал сумын Эрдэнэ-Уул багийн малчин Банзарын Сандагсүрэн;

-Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын 6 дугаар багийн малчин Гончигийн Манарбек, Толбо сумын 4 дүгээр багийн малчин Наресийн Ораз;

-Баянхонгор аймгийн Баянговь сумын Залаа багийн малчин Гаравын Гэрэлдаш, Баянлиг сумын 1 дүгээр багийн малчин Дэчигхоролын Гантулга, Баян-Овоо сумын Уранхайрхан багийн малчин Батдуламын Ёндон, Баян-Өндөр сумын 1 дүгээр багийн малчин Балжиннямын Саандар, Жаргалант сумын 2 дугаар багийн малчин Жавханы Рагчаасүрэн;

-Булган аймгийн Баян-Агт сумын Баянхайрхан багийн малчин Битүүгаагийн Бат-Эрдэнэ, Гурванбулаг сумын Агьт багийн малчин Нямсүрэнгийн Жамц, Орхон сумын Бүхт багийн малчин Намшингийн Баттулга, Сайхан сумын Мануулт багийн малчин Жадамбаагийн Дамдинсүрэн;

-Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Баянхонгор багийн малчин Пунцагийн Доржсүрэн, Есөнбулаг сумын Рашаант багийн малчин Чимэддоржийн Баярбаатар, Тонхил сумын Бүс-Уул багийн малчин Батжаргалын Төрмөнх, Халиун сумын Чацран багийн малчин Банзрагчийн Мулч;



-Говь-Сүмбэр аймгийн Баянтал сумын 2 дугаар багийн малчин Цэрэндоржийн Доржсүрэн;

-Дорноговь аймгийн Айраг сумын Нард багийн малчин Готовын Эрдэнэбулган, Хөвсгөл сумын Элст багийн малчин Галсаншадавын Ууганбаяр;

-Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Санжинт багийн малчин Лхагвагийн Цэвээн;

-Дорнод аймгийн Баян-Уул сумын Хар чулуут багийн малчин Батмөнхийн Батболд, Булган сумын 4 дүгээр багийн малчин Гомбын Оюунсүрэн, Сэргэлэн сумын 4 дүгээр багийн малчин Чулууны Галиа, Чойбалсан сумын Сүмбэр багийн малчин Будын Алтангэрэл;

-Дундговь аймгийн Дэрэн сумын 3 дугаар багийн малчин Шажингийн Мишигтаяа, Дэлгэрцогт сумын Цахиурт багийн малчин Лувсандагвын Эрдэнэбаяр, Өлзийт сумын 2 дугаар багийн малчин Долгорын Дашжамц, Сайхан-Овоо сумын 4 дүгээр багийн малчин Баярсайханы Адъяадорж, Сайнцагаан сумын 4 дүгээр багийн малчин Базарын Жаргалсайхан, Эрдэнэдалай сумын Сангийн далай багийн малчин Бавуугийн Цэндбаяр;

-Завхан аймгийн Их-Уул сумын Цэцүүх багийн малчин Чогсомжавын Далайбат, Сантмаргаз сумын Холбоо багийн малчин Ралхжавын Батсүх, Тэлмэн сумын Шургах багийн малчин Цэрэндоржийн Агваандаш, Идэр сумын Загастай багийн малчин Гончигийн Туваандамбий;

-Орхон аймгийн Жаргалант сумын Малчин багийн малчин Хорхойгийн Нямжав;

-Өвөрхангай аймгийн Баянгол сумын 5 дугаар багийн малчин Цоодолын Батсайхан, Баян-Өндөр сумын 1 дүгээр багийн малчин Гомбодоржийн Цэрэнпунцаг, Бүрд сумын 1 дүгээр багийн малчин Сэрээнэндоржийн Пунцаг, Нарийнтээл сумын 4 дүгээр багийн малчин Чимэддоржийн Дэгддорж, Хайрхандулаан сумын 2 дугаар багийн малчин Шадваагийн Дэлгэрдалай;

-Өмнөговь аймгийн Ноён сумын Ганзагад багийн малчин Цэрэндашийн Цэвээнравдан, Номгон сумын Эмгэнбулаг багийн малчин Зундуйгийн Амарсанаа, Сэврэй сумын Хоолт багийн малчин Даваагийн Гансүх;

-Сүхбаатар аймгийн Асгат сумын Их-Уул багийн малчин Баяраагийн Өсөхбаяр, Мөнххаан сумын 2 дугаар багийн малчин Дамдингийн Очирпүрэв,



Наран сумын Тосонгийн гол багийн малчин Өлзиймэндийн Гантулга, Халзан сумын 1 дүгээр багийн малчин Жамсранжавын Отгонбаатар;

-Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын 1 дүгээр багийн малчин Гончигсүрэнгийн Баасанжав, Жавхлант сумын 1 дүгээр багийн малчин Цэвээний Эрдэнэ, Орхон сумын Бэлэндалай багийн малчин Лхамзавын Баянмөнх, Орхонтуул сумын 2 дугаар багийн малчин Ганболдын Даваадорж;

-Төв аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар багийн малчин Сандагдоржийн Даваасамбуу, Баян сумын 1 дүгээр багийн малчин Доржпүрэвийн Энхболд, Баянжаргалан сумын 3 дугаар багийн малчин Чимэд-Очирын Цэрэндаваа, Баян-Өнжүүл сумын 3 дугаар багийн малчин Дашдэндэвийн Алтансэлэм, Эрдэнэсант сумын 2 дугаар багийн малчин Чимэдийн Галсандорж;

-Увс аймгийн Наранбулаг сумын Хужирт багийн малчин Санжийн Гомбо, Сагил сумын Өндөр мод багийн малчин Норжингийн Баттөмөр, Тэс сумын Баян-Овоо багийн малчин Баатарын Галсанжамц;

-Ховд аймгийн Буянт сумын Цагаанбургас багийн малчин Должинсүрэнгийн Отгонням, Дарви сумын Баянбулаг багийн малчин Рэнцэндоржийн Цэрэндорж, Мөст сумын Баянхайрхан багийн малчин Жавзангийн Төмөрөө, Үенч сумын Жаргалан багийн малчин Хинатын Бөрбай;

-Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын 3 дугаар багийн малчин Шагдарын Мачуухай, Шинэ-Идэр сумын Баянзүрх багийн малчин Алтангэрэлийн Ганболд;

-Хэнтий аймгийн Батноров сумын Эрдэнэчандмань багийн малчин Дугарын Наранчимэг, Хэрлэн сумын 8 дугаар багийн малчин Кажавын Асгалхан;

-Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 12 дугаар хорооны малчин Дагвын Гандибазар нарыг “Улсын сайн малчин”-аар;

б) Төв аймгийн Баянчандмань сумын Чандмань багийн “МОНЭГГ” ХХК-ийн “Баян” шувууны аж ахуй, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны “Зургаан хошуу” гахайн аж ахуйн эзэн Магсарын Золзаяа, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны иргэн Шанлавын Батсайхан, Төв аймгийн Баянчандмань сумын Чандмань багийн иргэн Ванчигийн Ганцолмон, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 13 дугаар хорооны иргэн Нансалын Оюунаа нарыг “Улсын тэргүүний фермер”-ээр;



в) Төв аймгийн Алтанбулаг сумын Аргал 2 дугаар багийн “Баянсонгинот” малчдын бүлгийг “Улсын тэргүүний малчдын бүлэг”-ээр;

г) Булган аймгийн Хангал сумын “Молор Эрдэнэ түрүү” ХХК, Дашинчилэн сумын “Өрхтий трейд” ХХК;

-Хөвсгөл аймгийн Тариалан сумын “Шижир говь” ХХК;

-Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Түмэн буудай” ХХК;

-Орхон аймгийн Жаргалант сумын “Бүтлийн ундарга” ХХК, “Алтантошлой” ХХК;

-Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын “Баян Сэлэнгэ” ХХК, Хушаат сумын “Элит үр” ХХК, Орхонтуул сумын “Агрошим” ХХК;

-Төв аймгийн Цээл сумын “Цээлийн хур” ХХК, Угтаалцайдам сумын “Виетпрогресс” ХХК, Жаргалант сумын “Болдтулга” ХХК-ийг “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-оор;

д) Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын иргэн Асхарын Бахытбек;

-Говь-Алтай аймгийн Жаргалан сумын иргэн Батжаргалын Мөнх-Эрдэнэ;

-Булган аймгийн Булган сумын иргэн Гоюусангийн Жаргалсайхан;

-Орхон аймгийн Жаргалант сумын иргэн Чогсомын Баясгаланцэцэг;

-Дархан-Уул аймгийн Орхон сумын иргэн Жамцын Отгонбаатар, мөн сумын иргэн Балжхүүгийн Үүрцайх;

-Төв аймгийн Жаргалант сумын иргэн Оригийн Бямбадорж, Борнуур сумын иргэн Цэрэндоржийн Дамба, Цээл сумын “Бугын ам” ХХК-ийн механикжуулагч УсаннахиагийнТөмөрбаатар, Угтаалцайдам сумын “Чандмань дөл” ХХК-ийн механикжуулагч Наваантаягийн Энхбат;

-Увс аймгийн Улаангом сумын иргэн Гэлэнхүүгийн Даваа, Тариалан сумын иргэн Гонийн Самбуу;

-Хөвсгөл аймгийн Тариалан сумын иргэн Жадамбын Баатар;



-Ховд аймгийн Буянт сумын иргэн Идэшийн Батсүх, мөн сумын иргэн Цагааны Шинэбаяр, Жаргалант сумын иргэн Чулуунхүүгийн Дэмбэрэл;

-Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын “Суварган тамир” ХХК-ийн механикжуулагч Долгорын Ганхуяг, Түшиг сумын “Анх тамир” ХХК-ийн механикжуулагч Бандийн Алтангэрэл, мөн сумын “Сэлэнгийн тариалан” ХХК-ийн механикжуулагч Банжаагийн Мөнхжаргал, Хушаат сумын “Цэгээн хуст” ХХК-ийн механикжуулагч Очиржанцангийн Баярдалай, Цагааннуур сумын “Товхонхан” ХХК-ийн механикжуулагч Тунгалагийн Гантөмөр нарыг “Улсын тэргүүний тариаланч”-аар тус тус шалгаруулж шагнасугай.

2. “Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”, “Улсын тэргүүний малчдын бүлэг”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч”-ийн шагналд шаардагдах хөрөнгийг төсвийн багцдаа багтаан зохицуулан гаргахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад зөвшөөрсүгэй.

3. “Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”, “Улсын тэргүүний малчдын бүлэг”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, Улсын тэргүүний тариаланч”-ийн шагналыг тухайн орон нутагт нь гардуулах ажлыг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД**

Р.БУРМАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 2 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.



2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 139 дүгээр тогтоол, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2010 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 79 дүгээр тогтоол, “Журамд өөрчлөлт оруулах болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 328 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2015 оны 41 дүгээр
тогтоолын хавсралт

**АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛБӨР АВАХ, ХӨНГӨЛӨЛТ
ҮЗҮҮЛЭХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Ажлын байрны төлбөр гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн (цаашид “байгууллага” гэх) гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө хуулиар ногдуулсан төлбөрийг ойлгоно.

1.3. Гадаадын иргэнд сар бүр ногдуулах ажлын байрны төлбөрийн хэмжээ нь Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

Хоёр. Ажлын байрны төлбөр авах

2.1. Байгууллага нь гадаадын иргэнд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахдаа Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8.1-д заасан хөдөлмөрийн



асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний эрх олгосон байгууллага (цаашид “эрх бүхий байгууллага” гэх)-д ажлын байрны төлбөрийг урьдчилан төлнө.

2.2. Эрх бүхий байгууллага ажлын байрны төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дансанд төвлөрүүлэх бөгөөд ажлын байрны төлбөр төлсөн эсхүл хөнгөлөлт үзүүлсэн, чөлөөлсөн тухай бүртгэл хөтөлнө.

2.3. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаадын иргэн тухайн байгууллагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээ хугацаанаас нь өмнө цуцалж, буцсан тохиолдолд уг байгууллагын хүсэлт болон иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг үндэслэн урьдчилан төлсөн төлбөрийн зөрүүг тухайн төсвийн жилд багтаан буцаан олгоно.

Гурав. Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

3.1. Дор дурдсан гадаадын иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө:

3.1.1. Монгол Улсад суугаа гадаад орны дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтан, түүний гэр бүл;

3.1.2. олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар (НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын салбар гэх мэт)-т ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүл;

3.1.3. боловсролын байгууллага, шинжлэх ухааны салбарт гэрээгээр ажиллаж байгаа гадаадын зөвлөх, мэргэжилтэн, багш, эрдэм шинжилгээний ажилтан;

3.1.4. Засгийн газар хоорондын гэрээнд заасан тохиолдолд уг гэрээний дагуу ажиллаж байгаа мэргэжилтэн, ажилтан;

3.1.5. Монгол Улсын олон улсын гэрээ болон төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу ажиллаж байгаа сайн дурын ажилтан;

3.1.6. хууль ёсны зөвшөөрөл авч Монгол Улсад хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын төрийн бус (ашгийн бус) байгууллагын ажилтан.



3.2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагч, гишүүн, удирдах бүрэлдэхүүний 3 хүртэлх төлөөлөгчийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг үндэслэн ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө.

3.3. Байгалийн гамшиг, сүйрлийн хор хөнөөлийг арилгахад шаардагдах ажиллах хүч, мэргэжилтнийг дотоодоос хангах бололцоогүй нөхцөлд гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах бол Засгийн газрын шийдвэрээр ажлын байрны төлбөрөөс чөлөөлж болно.

3.4. Эдийн засагт онцгой ач холбогдол бүхий шинэ технологи нэвтрүүлэх, импортыг орлох, экспортод чиглэсэн үйлдвэрлэл эрхлэх, нийтийн хэрэглээний зориулалттай төмөр зам, нисэх буудал, цахилгаан болон дулааны станц, олон улсын сүлжээний дээд зэрэглэлийн зочид буудал, метро барих бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхэд гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах тохиолдолд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газрын шийдвэрээр ажлын байрны төлбөрөөс чөлөөлж, хөнгөлж болно.

3.5. Төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлагийн урилга болон гэрээний дагуу судалгаа, шинжилгээ хийлгэх, зөвлөгөө авах зорилгоор гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах тохиолдолд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлнө.

3.6. Гадаадын ажилтан, мэргэжилтнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөхөд Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газар, яам, Засгийн газрын агентлагийн байгуулсан гэрээ, тухайн иргэний мэргэжлийн диплом, үнэмлэх, байгууллагын хүсэлтийг тус тус үндэслэнэ.

3.7. Монгол Улсад албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч, цагаач иргэн болон Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаад иргэнээс энэ журамд заасан төлбөрийг авахгүй.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллага нь ажлын байрны төлбөрийн талаарх тайланг улирал тутам гаргаж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.2. Энэхүү журамд заасны дагуу төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх гадаадын ажилтан, мэргэжилтний талаар байгууллага нь үнэн зөв тодорхойлолт гаргах үүрэгтэй.



4.3. Байгууллага ажлын байрны төлбөрийг 1 сараас дээш хугацаагаар төлөөгүй нөхцөлд эрх бүхий байгууллага тухайн гадаадын иргэний хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгож, энэ тухай иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

4.4. Энэ журмыг зөрчсөн байгууллагад Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 12.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.5. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэхүү журмын биелэлтэд хяналт тавина.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 14003